

FOREIGN INVESTMENT TREND IN MONGOLIA'S CONSTRUCTION AND URBAN DEVELOPMENT SECTOR

Statement by Mr.J.Narantsatsralt, Minister of
Construction and Urban Development of
Mongolia at the Panel F Session of “Mongolia:
Investors’ Forum 2006”

Distinguished Delegates,
Ladies and Gentlemen,

It is my honor to welcome all of you to the “Mongolia: Investors’ Forum 2006” being held within the framework of the celebration of 800th Anniversary of Statehood of Great Mongolia. I am pleased to also mention here that this Forum is coinciding with 80th Anniversary of the Construction Sector of Mongolia.

I am confident that this Forum will provide you with useful information and insights on current situation of and further foreign investment potentials in the construction sector of Mongolia. I believe that the distinguished participants will freely discuss your thoughts and deliberations and will actively and constructively participate in this Forum.

Ladies and Gentlemen,

Except some depressions experienced during the 1990s, the construction sector of Mongolia has been successfully developed during the last eight decades.

As of today some 1000 construction erection companies, 190 construction design companies and 250 building material producers, collectively employing over 30,000 engineering technical staff and skilled workers, are operating country-wide. Among those there are 90 construction, 5 construction design and over 50 building material companies with foreign investment.

I would like to highlight here the volume of construction erection and rehabilitation works performed by the construction sector, which has grown annually by 3-30%. In monetary terms such growth constitute from 77,1 billion tugrics in 2000 to 174.2 billion and 179.7 billion tugrics respectively in 2004 and 2005.

Out of construction erection and rehabilitation works in amount of 179.1 billion tugrics performed last year, works of 147.1 billion and 32 billion tugrics or 17.9% were performed respectively by the domestic companies and companies with foreign investment.

Compare to the state owned enterprises which performed last year construction erection works of 36.7 billion tugrics, the private companies dominated in the construction market by performing works of 94.9 billion tugrics, which is higher by 9 billion tugrics or 10.5% against 2004. Performance by the foreign invested companies in 2005 also increased by 5.5 billion tugrics or 55.5% against 2004.

Given such increased demand and growth of construction works, volume and diversity of design works and building material industry have been increased on annual basis. For the last four years more that 20 new building material plants were put into operation allowing to locally produce some of the building materials which had been imported before. As a result building material industry produced in 2005 products valued at 18.3 billion tugrics compare to 6 billion in 2000.

The Government of Mongolia has been actively encouraging foreign investment and assistance in the construction sector, as a result, number of projects and programs has been implemented and many are well under their implementation.

As of today four projects are being implemented with foreign direct investment, four under soft loans and ten with grant aid. The examples of ongoing projects include “Four Season Gardens” invested by Japanese company Suruga, “Moscow District” with Russian investment, “Silver Prague” invested by Czech company Hanzl, and “Marshal Town” invested by the USA.

Number of projects and programs are being successfully implemented including World Bank funded “Ulaanbaatar Services Improvement Project II”, ADB funded “Housing Finance Sector Project” and “Integrated Development of Basic Urban Services in Provincial Towns Project”, as well as “Improving Living Environment of Ger Areas in Mongolian Towns Project”, “Integrated Urban Development Program”, and “Commercialization of Super Insulated Buildings in Mongolia” Project funded respectively by JFPR, GTZ and joint UNDP and GEF grant aids.

Moreover, preparatory works have been completed for the implementation of “Training of Skilled Workers in Construction Sector”, “Urban Development and Housing Sector Project”, and “Energy Efficient Buildings” projects to be respectively funded by JFPR grant aid, ADB soft loan and joint UNDP and GEF grant funds.

Ladies and Gentlemen,

The Government of Mongolia defined its goal in the construction and urban development sector as “... to ensure increased housing supply, improved quality, productivity and efficiency of the construction sector by developing and implementing adequate urban development and land management policies of Mongolia.” Under this overarching goal, the Government has initiated several important activities to develop and implement the most efficient urban development system in the country; provide land administration, geodesy and cartography with adequate policies and guidance; encourage land privatization; develop policies to ensure economic circulation of land, create favorable legal and economic environment for the entities operating in the construction sector; ensure accessibility of the citizens to long-term mortgage lending facilities for ownership of adequate housing; and enhance international cooperation in the sector. In addition, the Government encourages cooperation with domestic and foreign investors who propose advanced technology and sophisticated innovations, and with business communities who support development activities in the construction sector of Mongolia.

I would like to briefly mention here some completed and ongoing activities for improving legal framework of the construction sector.

In line with the objectives stated in the Government Action Program as to (i) advance construction sector development to an international level, (ii) introduce community participatory approach in urban planning, (iii) improve housing supply and infrastructure provision, (iv) construct multi-story apartment buildings affordable for the citizens, and (v) create housing mortgage system and improve legal framework for its implementation, the Parliament of Mongolia passed and enforced in 2005 the “Law on the Value Added Tax Exemption of Some Materials, Machinery, Goods, Works and Services” and “Law on Customs Duties Exemption of Some Materials, Machinery, Goods, Works and Services”.

According to the above legislations machinery and equipment imported for the purpose of technical and technological modernization of the construction sector are being exempted from the VAT and customs duties.

The Ministry of Construction and Urban Development (MCUD) jointly with the Ministry of Finance, National Tax Authority and General Customs Office established a task force and developed guidelines stipulating procedures for exemption from, deduction of, and reimbursement for VAT and customs duties.

As of 1 July 2006, VAT and customs duties in amount of USD1.00 million that supposed to be imposed on machinery and equipment imported by 90 entities were exempted.

In 2006 activities for improving legislative framework of the construction sector have been focused on to revise in accordance with the current requirements and enforce the "Construction Law", "Procedure for Putting the Buildings into Operation", "Procedure for Issuing Permission for Start-up and Continuation of Construction Works", and "Guidelines for Employers of Construction Activities". In addition, revision and updating of construction codes and bill of quantity codes are being undertaken in accordance with the set plan. Moreover, we are conducting activities targeted at introduction of new techniques, technologies, material, and structural elements through updated codes.

Ladies and Gentlemen,

Housing stock of Mongolia increased from 6474.4 thousand m² in 2000 to 7127.4 thousand m² in 2004. In 2005 some 3165 housing units were built country-wide. For the last few years housing construction accounted for about 30% of total construction works performed in the country.

With aim to implement provision of the Government Action Plan stipulated as "The Government will support construction material industry", one of the objectives in front of us would be to` renovate old plants and facilities for building material production to facilitate their increased competitiveness, meanwhile, create enabling environment to support production of export oriented new construction materials as well as those which would replace currently imported ones.

During the last four years over 70 small building material plants were put into operation, out of which 20 were launched in 2005, allowing to locally produce some of the materials that had been imported before. Thanks to this, total number of construction material plants reached over 60 in 2005 and output of the construction material industry rose from 6 billion tugrics in 2000 to 17 billion tugrics in 2005.

Namely, production facilities for color tiles for surfacing foot paths and squares, PVC panels for insulation, PVC-framed windows and doors, metal doors, PVC-pipes for water supply and sewerage system, PVC-elements, ceramic bath tubs, sink and other sanitation equipment, wall blocks, lightweight concretes, perlite concrete, mineral-wool concrete, clay die aggregate, dry plastering, facing bricks, roofs, sand-cement tiles etc. have been launched.

Besides supporting development of small and medium building material plants, the MCUD is exerting specific attention to the improvement of quality of construction materials, thus, is collaborating in policy framework with State Inspection Agency and other related NGOs for strengthening quality control mechanism.

In 2005 the Standard Sub-Committee on Construction, which is aimed to supply the consumers with building materials with adequate quality and introduce new sophisticated material and technologies to the production, developed 52 new and revised 5 existing standards and invalidated 8 standards, in total got approved 65 standards by the National Center of Standardization and Measurement.

The Government is working to implement its objective to develop public utilities sector in coordination with population settlement patterns and future urban development trends, supply the population with potable water consistent with required standards, ensure reliable operation of water supply system, ensure efficient use of water resources, and improve operation of waste water treatment plants. Number of projects is being implemented with assistance of ADB, World Bank and other donor agencies and countries in this sector, namely, "Integrated Development of Basic Urban Services in Provincial Towns Project", "Ulaanbaatar Services Improvement Project II", "Waste Water Treatment Plant Project in Ulaanbaatar" and "Improvement of Water Supply Facilities in Ulaanbaatar Project". Preparation works are being conducted for the implementation of projects to improve water supply system and Waste Water Treatment Plant in Erdenet city and water supply system in Darkhan, Sukhbaatar and Altanbulag cities.

With official development assistance of the Czech Republic the projects for improving water supply in rural areas and suburban ger areas of Ulaanbaatar city are going to be commenced.

Ladies and Gentlemen,

Based on the assessment of the current status of and challenges encountering construction sector the future development directions for the sector have been identified. We are working to implement them, hence, we would like to draw your attention to the following activities being contemplated.

- The MCUD is giving priority to and proposing for your consideration the "40,000 Housing Program", "Airport City Project" and "Improved Water Supply Project". These projects will be separately presented by our presenters. Others include:
- Training of skilled workers in construction sector, for this purpose strengthen training facilities of and ensure normal operation by the training institutions;
- Support to the introduction of advanced technologies, sophisticated techniques, material and structural elements into production;
- Implementation of the projects targeted at improved housing supply for and housing condition of the population;
- Fund raising for housing construction and infrastructure provision, issue Government Bonds and Securities to finance some portion of the fund. Recently, the Parliament endorsed the issue of Government Bonds with value of 60 billion tugrics.
- Improving construction code system, design and engineering-geological survey works in line with conditions of market relations;
- Revision and updating technology, quality and standards of structural elements for buildings;
- Improving quality control system for building materials, developing binding material industry in line with the market demand; and creating legal framework that would ensure national security;
- Introducing energy efficient technologies, increasing production of insulation materials, lightening and diversifying structural elements;
- Undertaking preventive actions from earthquake; and
- Developing and implementing programs for technical modernization for the sector.

We also prepared draft revisions of "Construction Law", "Urban Development Law", "Law on Legal Status of Cities and Villages", draft law on "Mortgage Backed Securities", and Master Plan for "40,000 Housing Program".

Actions are being undertaken to develop programs and plans for turning Kharkhorin and Erdenezuu towns into model tourism cities. Our long-term plans also include re-development of Khanbogd soum in Southgobi aimag into the city with modern design and planning based on Oyu Tolgoi mining deposit.

The Government is taking actions to enhance foreign relations in the construction sector, study construction methodologies, materials, techniques and technology of the countries with technical and technological advancement, and participate in international construction fairs and exhibitions.

Although the Government of Mongolia is working towards achieving development goals identified for construction sector, it does recognize the need to attract foreign investors for the implementation of specific projects, continuously introduce new technologies from abroad, regularly send its human resources to the developed countries for training and re-training, thus, I would like to stress out here that we are ready to cooperate with you in the above fields.

I am confident that we will come up with many new thoughts and ideas from this Forum which would facilitate the implementation of specific projects and programs with foreign investment. I wish successful participation all of you in this Forum.

Thank you for your attention.

МОНГОЛ УЛСЫН БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЛБАРТ ОРУУЛАХ ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

(Барилга, хот байгуулалтын сайд Ж. Наранцацралтын
“Монгол Улс: Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт- 2006”-ын
салбар хуралдаан дээр тавих илтгэл)

Ноёд хатагтай нараа !

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгаж, мэндчилье.

“Монгол Улс: Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт - 2006” нь Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдаж байгаагаараа онцлогтойгоос гадна Монгол Улсад барилгын салбар үүсэж хөгжсөний 80 жилийн түүхэн ой тохиож байгааг энд дурьдахад таатай байна.

Энэхүү “Монгол Улс: Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт-2006” чуулга уулзалтаар хөрөнгө оруулагчид Монгол Улсын барилгын салбарт хөрөнгө оруулалт хийх боломжийн талаар болон Монгол Улсын барилгын салбарын өнөөгийн байдлын талаар тодорхой ойлголт, мэдээлэлтэй болох боломжтойгоос гадна барилгын салбарын хөрөнгө оруулалтын талаар энд хүрэлцэн ирсэн зочид, төлөөлөгчид санал бодлоо чөлөөтэй илэрхийлж, ажил хэрэгчээр оролцоно гэдэгт итгэж байна.

Монгол Улсын Барилгын салбар зах зээлийн харилцаанд шилжиж эхэлсэн 1990-ээд онуудад нэг хэсэг хугацаанд зогсонги байдалд орсныг эс тооцвол өнгөрсөн 80 жилийн хугацаанд амжилттай хөгжиж ирсэн билээ.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд /2006 оны эхний хагас жилийн байдлаар/ барилга угсралтын 1000 гаруй байгууллага, зураг төсөл, хайгуулын 190, барилгын материалын үйлдвэрлэлийн 250 байгууллага үйл ажиллагаа явуулж эдгээрт 30,0 гаруй мянган инженер техникийн болон мэргэжлийн ажилчид ажиллаж байна. Эдгээрээс гадаадын хөрөнгө оруулалттай барилга угсралтын 90, зураг төсөл хайгуулын 5, барилгын материалын үйлдвэрлэлийн 50 гаруй байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна.

Гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлын хэмжээ 1998 онд 57,2 тэрбум төгрөг, 2000 онд 77,1 тэрбум төгрөг, 2004 онд 174.2 тэрбум төгрөг, өнгөрсөн 2005 онд 179.1 тэрбум төгрөгийн ажил хийгдэж жил тутам дунджаар 3-30 %-иар өсч байгааг энд цохон тэмдэглэхийг хүсч байна.

Өнгөрсөн 2005 онд 179.1 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсний 82.1 хувь буюу 147.1 тэрбум төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллагууд, 17.9 хувь буюу 32.0 тэрбум төгрөгийн ажлыг гадаадын барилгын байгууллагууд гүйцэтгэсэн байна.

Дотоодын барилгын байгууллагуудын гүйцэтгэсэн ажлаас 36.7 тэрбум төгрөгийн ажлыг улсын байгууллага, 94.9 тэрбум төгрөгийн ажлыг хувийн хэвшлийн байгууллага гүйцэтгэсэн нь 2004 оныхоос 10.5 хувь буюу 9.0 тэрбум төгрөгөөр, 15.4 тэрбум төгрөгийн ажлыг гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан аж ахуйн нэгжүүд гүйцэтгэсэн нь урьд оныхоос 5.5 тэрбум төгрөгөөр буюу 55.5 хувиар өсчээ.

Барилгын ажлын энэхүү өсөлт, хэрэгцээтэй уялдан барилгын зураг төслийн байгууллагуудын ажлын хэмжээ болон барилгын материалын үйлдвэрлэлтийн хэмжээ, нэр төрөл жил тутам өсөж ирэв. Сүүлийн 4 жилд барилгын материалын 20

гаруй жижиг үйлдвэр шинээр ашиглалтад орж, импортоор авдаг байсан зарим төрлийн барилгын материалыг дотооддоо үйлдвэрлэдэг боллоо. Ингэснээр 2000 онд 6 тэрбум төгрөгний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг байсан бол 2005 онд барилгын материалын үйлдвэрүүдэд 18.3 тэрбум төгрөгний бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна.

Монгол Улсын Засгийн газар барилгын салбарт гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх тал дээр идэвхи санаачлагатай ажиллаж ирсэн бөгөөд үүний үр дүнд цөөнгүй төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж, зарим нь хэрэгжих шатандаа явж байна.

Өнөөгийн байдлаар манай салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалтаар дөрвөн төсөл, хөнгөлөлттэй зээлээр дөрвөн төсөл, буцалтгүй тусламжаар арван төсөл хэрэгжиж байна.

Тухайлбал: Японы Суруга компаний хөрөнгө оруулалтаар “Дөрвөн улирлын цэцэрлэг”, ОХУ-ын хөрөнгө оруулалтаар “Москва хороолол”, БНЧех улсын “Ханзл” компаний хөрөнгө оруулалтаар “Мөнгөн Прага”, АНУ-ын хөрөнгө оруулалттай “Маршал хотхон” зэрэг орон сууцны иж бүрэн хорооллын төслүүд хэрэгжиж эхлээд байна.

Дэлхийн банк, АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр Улаанбаатар хотын болон орон нутгийн хотуудын НАА-г сайжруулах төсөл, Даян дэлхийн байгаль орчны сан, НҮБ-ын буцалтгүй тусламжаар “Дулааны хэмнэлттэй хувийн орон сууцыг зах зээлд нэвтрүүлэх төсөл”, АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр Орон сууцны санхүүжилтийн төсөл, Японы ядуурлыг буруулах сангийн буцалтгүй тусламжаар Гэр хорооллын нөхцөл сайжруулах төсөл, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн санхүүжилтээр Хотын иж бүрэн хөгжил, барилгын салбарыг дэмжих төсөл зэрэг төсөл, хөтөлбөрүүд амжилттай хэрэгжиж байна.

Мөн Японы Ядуурлыг буруулах сангийн санхүүжилтээр Барилгын салбарт мэргэжилтэй ажилчид бэлтгэх төсөл, АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр Хот байгуулалт, орон сууцны төсөл, Даян дэлхийн байгаль орчны сан, НҮБХХ-ийн буцалтгүй тусламжаар Эрчим хүчний хэмнэлттэй барилгын төсөл тус тус хэрэгжих бололцоо бүрдээд байна.

Монгол Улсын Засгийн газраас Барилга, хот байгуулалтын чиглэлээр баримтлах зорилгоо “Монгол Улсын хот байгуулалт, газрын харилцааны оновчтой бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх замаар барилгын салбарын үр ашиг, бүтээмж, чанар болон орон сууцны хангамжийг дээшлүүлэхэд оршино” гэж тодорхойлсон юм. Энэхүү зорилгын хүрээнд Монгол улсын Засгийн газраас хот байгуулалтын хамгийн үр ашигтай тогтолцоог бий болгон хөгжүүлэх, газрын харилцаа, геодези зураглалыг зохистой бодлогоор удирдах, газрыг хувьчлах, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах бодлогыг боловсруулах, барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудад хууль эрх зүйн болон эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх, иргэдэд урт хугацаатай зээлийн хөрөнгийн эх үүсвэрээр тохилог орон сууцтай болох нөхцлийг хангах, салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг шинэлэг санаа, дэвшилтэт техник технологийг санал болгосон гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид болон барилгын салбарын их бүтээн байгуулалтын үйл ажиллагааг дэмжсэн ажил хэрэгч хүмүүстэй хамтран ажиллах олон чухал ажлын эхлэлийг тавиад байна.

Ингээд юуны өмнө барилгын салбарын хууль, эрх зүйн хүрээнд хийсэн болон хийгдэж байгаа зарим ажлуудаас товч дурьдахыг хүсэж байна.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан барилгын салбарын хөгжлийг шинэ түвшинд гаргаж олон нийтийн оролцоотой хот төлөвлөлтийг бий болгох; иргэдийн орон сууцны хангамж, дэд бүтцийг сайжруулах,

иргэдийн худалдан авах чадварт нийцсэн нийтийн болон олон давхар орон сууцны барилга барих; орон сууцны зээлийн тогтолцоог бүрдүүлэх түүний хэрэгжилтийг хангахтай холбогдсон хууль эрх зүйн орчныг сайжруулах ажлын хүрээнд “Зарим материал, машин механизм, тоног төхөөрөмж, бараа, ажил, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай”, “Зарим материал, тоног төхөөрөмж, машин механизмыг гаалийн албан татвараас чөлөөлөх тухай” Монгол улсын хуулиудыг Улсын Их Хурлаас 2005 онд батлан гаргаж мөрдүүлж байна.

Дээрх хуулиудын дагуу барилгын салбарт техник, технологийн шинэчлэл хийх зориулалттай импортоор оруулж ирж буй зарим үндсэн машин механизм, тоног төхөөрөмжийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Манай яамнаас Сангийн яам, Үндэсний татварын газар, Гаалийн ерөнхий газартай хамтран ажлыг хэсэг байгуулан ажиллаж, гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг хэрхэн, ямар зарчмаар чөлөөлөх, суутган тооцох, буцаан олголт хийх зэрэг үйл ажиллагааг зохицуулсан журмыг боловсруулсан.

Оны эхний хагас жилийн байдлаар 90 орчим компанийн импортоор оруулж ирсэн машин механизм, тоног төхөөрөмжид ногдох 1.0 сая гаруй ам.долларыг гаалийн болон импортын нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн.

2006 онд барилгын салбарын хууль, эрх зүйн орчинг сайжруулах ажлын хүрээнд “Барилгын тухай” хууль, “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”, “Барилга угсралтын ажлыг эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох журам”, “Барилгын захиалагчийн дүрэм” зэрэг баримт бичгүүдийг өнөөгийн шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлан мөрдүүлэхээр ажиллаж байна. Түүнчлэн барилгын норм, норматив, төсвийн норм, үнэлгээг шинэчлэх, боловсронгуй болгох ажлыг төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлж байгаагийн гадна барилгын үйлдвэрлэлд сүүлийн үеийн шинэ техник, технологи, материал, хийц эдлэл нэвтрүүлэх ажлыг барилгын норм, нормативаар дамжуулан хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Монгол Улсын орон сууцны фонд 2000 онд 6474.4 мян.м² байсан бол 2004 онд 7127.4 мян.м² болж нэмэгдсэн байна. 2005 онд 3165 айлын орон сууц ашиглалтад оруулсан. Сүүлийн жилүүдэд барилга угсралтын нийт ажлын 30 орчим хувийг орон сууцны барилгад гүйцэтгэсэн байна.

“Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжинэ” гэсэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн заалтыг хэрэгжүүлэхийн тулд урьд нь ажиллаж байсан хуучин үйлдвэрүүдийн үйл ажиллагааг сэргээн, тэдгээрийн техник, технологийг шинэчлэж, зах зээлд өрсөлдөх чадавхитай болгохын зэрэгцээ шинэ дэвшилттэй техник, технологи эзэмшин нутагшуулах замаар импортын бүтээгдэхүүнийг орлохуйц, экспортын баримжаатай шинэ шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг бүрдүүлэх зорилго тавигдаж байна.

Сүүлийн 4 жилд барилгын материалын 70 гаруй жижиг үйлдвэр, үүнээс 2005 онд 20 орчим жижиг үйлдвэр шинээр ашиглалтад орж, импортоор авдаг байсан зарим төрлийн барилгын материалыг дотооддоо үйлдвэрлэдэг боллоо. Ингэснээр 2000 онд 6 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг байсан бол 2005 онд барилгын материалын 60 гаруй үйлдвэрт 17 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бөгөөд цаашид барилгын материалын үйлдвэрлэлийн нэр, төрөл өргөжиж байна.

Тухайлбал, зам, талбайн өнгөлгөөний өнгөт хээтэй хавтан, дулаалгын хөөсөнцөр полистрол хавтангийн, хуванцар хүрээтэй вакуум хаалга, цонхны, төмөр

хаалганы, бохир, цэвэр усны хуванцар хоолой буюу хуванцар эдлэлийн, сантехникийн болон ванн, угаагуурын шаазан эдлэхүүний, барилгын ханын төрөл бүрийн блокны, хийн хөнгөн бетоны, перлит бетоны, эрдэс хөвөн бетоны, керамзит дүүргэгчийн, хуурай өнгөлгөө шавардлагын, өнгөлгөөний тоосгоны, дээврийн, элс, цементэн черепицийн гэх мэт олон төрөл, зориулалтын үйлдвэрүүд ашиглалтанд орлоо.

Барилгын материалын жижиг, дунд үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх боломжийг бүрдүүлж, дэмжлэг, туслалцаа үзүүлэхийн зэрэгцээ бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэхэд онцгой анхаарч, чанарт тавих механизмыг боловсронгуй болгоход улсын хяналтын байгууллагууд, холбогдох төрийн бус байгууллагуудтай яамны зүгээс бодлогын хүрээнд хамтран ажиллаж байна.

Хэрэглэгчдийг чанартай бүтээгдэхүүнээр хангах, шинэ дэвшилтэт материал, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх салбарын стандартын хорооноос 2005 онд 52 стандартыг шинээр, 5 стандартыг дахин хянаж, 8 стандартыг хүчингүй болгон, нийт 65 стандартыг СХҮТ-өөр батлуулаад байна.

Нийтийн аж ахуйн салбарыг хүн амын байршил, хот суурин газрын хэтийн төлөвтэй уялдуулан хөгжүүлэх, хүн амыг стандартын шаардлагад нийцсэн ундны усаар хангах, усан хангамжийн системийн найдвартай ажиллагааг хангах, усыг хэмнэлттэй ашиглах, цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг сайжруулах зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Тус салбарт Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк болон хандивлагч бусад орны зээл тусламжаар “Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйг хөгжүүлэх 2-р шатны төсөл”, “Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах төсөл”, “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл”, “Улаанбаатар хотын цэвэр усны дээд эх үүсвэрийн тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл” хэрэгжиж цаашид Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламж, цэвэр усны эх үүсвэрийн төсөл, Алтанбулаг, Сүхбаатар, Дархан хотын цэвэр усны эх үүсвэрийн тоног төхөөрөмжийг сайжруулах төслүүдийг хэрэгжүүлэхээр бэлтгэл ажил хийгдэж байна.

БНЧех Улсын хөгжлийн тусламжаар хөдөө орон нутгийн ундны усны хангамж, чанарыг сайжруулах, Улаанбаатар хотын захын хорооллын ундны усны хангамжийг сайжруулах төслүүд хэрэгжиж эхлэх гэж байна.

Барилгын салбарын одоогийн байдал, тулгамдсан, онцгой ач холбогдол бүхий шийдвэрлэвэл зохих асуудлуудыг судлан үзэж цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлон, тэдгээрийг хэрэгжүүлэхээр дараах арга хэмжээ, чиглэлүүдийг баримтлан ажиллаж байгаа бөгөөд энэ чиглэлд хөрөнгө оруулагч Та бүхний анхаарлыг хандуулах саналтай байна. Үүнд:

- БХБЯ нь “40000 орон сууц” төсөл, “Airport city буюу Нисэх буудлын хотхон” төсөл болон “Ундны усан хангамжийг сайжруулах” төслүүдэд тэргүүлэх ач холбогдол өгч та бүхэнд санал болгож байна. Эдгээр төслүүдийн талаар илтгэгч нар тус бүрт нь танилцуулах болно.

- Барилгын мэргэжилтэй ажилчдыг сургаж бэлтгэх, үүний тулд сургалтын байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэн хэвийн ажиллагааг хангах

- Сүүлийн үеийн ололт, шинэ техник, технологи, дэвшилтэт материал, хийц эдлэлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх:

- Орон сууцны хангамж, гэр хорооллын нөхцлийг сайжруулахад шаардлагатай төслүүдийг хэрэгжүүлэх,

- Орон сууц, түүний дэд бүтцийг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, хөрөнгийн тодорхой хэсгийг улсаас хангах зорилгоор орон сууцны бонд, үнэт цаас гаргах. Саяхан Монгол Улсын Их Хурлаас орон сууцны барилгын ажлын

санхүүжилтийг дэмжих зорилгоор 60 тэрбум төгрөгийн бондыг гаргахыг зөвшөөрөөд байна.

-Салбарын норм, нормативын баримт бичиг, зураг, төсөл, хайгуул, судалгааны ажлыг зах зээлийн харилцааны нөхцөлд нийцүүлэн боловсронгуй болгох

-Барилгад хэрэглэх хийц, бүтээцийн технологи, чанар, стандартыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн боловсруулах

-Барилгын материалын чанарт тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, барилгын барьцалдуулагч материалын үйлдвэрлэлийг зах зээлийн харилцааны эрэлт, шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх, улмаар үндэсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин бүрдүүлэх

-Дулаан, эрчим хүчний хэмнэлттэй технологийг нэвтрүүлэх, дулаан тусгаарлах материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хийц эдлэхүүний жинг хөнгөвчлөх, нэр төрлийг олшруулах

-Газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх

-Салбарын техникийн шинэчлэлийн хөтөлбөр, төслүүдийг боловсруулж хэрэгжүүлэх зэрэг болно.

Бид мөн МУ-ын “Барилгын тухай”, “Хот байгуулалтын тухай”, “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай” “Ипотекээр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн төслийг шинээр боловсруулах болон “Дөчин мянган орон сууц хөтөлбөр”, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах ажлыг хийгээд байна.

Хархорин хотыг жишиг хот болгох, Хархорин, Эрдэнэзуу орчмыг хот төлөвлөлтийн орчин үеийн аргачлалаар жуулчдын төв хот болгон хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөлтийн төслийг боловсруулахаар ажиллаж байна. Мөн Оюу толгой ордыг түшиглэн Өмнөговь аймгийн Ханбогд сумыг орчин үеийн төлөвлөлт, шийдэлтэй хот болгон хөгжүүлэх хэтийн төлөвлөгөөтэйгээр ажиллаж байна.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас Барилгын салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, техник, технологи өндөр хөгжсөн орнуудын шинэ материал, техник, технологи, арга барилыг судлах, барилгын олон улсын үзэсгэлэн яармагт оролцох зэрэг чиглэлээр нилээд ажлуудыг хийж байна.

Монгол Улсын Засгийн газраас Барилга, хот байгуулалтын чиглэлээр тавьсан зорилтоо хэрэгжүүлэн ажиллаж байгаа хэдийч гадаадын хөрөнгө оруулагчдыг татаж тодорхой төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, гадны шинэ техник, технологийг өөрийн оронд байнга нэвтрүүлж байх, боловсон хүчнээ өндөр хөгжилтэй орнуудад сургах ажлыг тасралтгүй зохион байгуулах шаардлагатайг бид ойлгож энэ чиглэлээр Та бүхэнтэй хамтран ажиллахад бэлэн байгааг энд зориуд онцлон тэмдэглэмээр байна.

Энэхүү чуулга, уулзалтаас хөрөнгө оруулалтын олон шинэлэг санал, санаачлага төрж хөрөнгө оруулалтын тодорхой хөтөлбөр төсөл хэрэгжих бололцоо тавигдана гэж найдан Та бүгдийг чуулга уулзалтдаа амжилттай оролцохыг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.